**ХӨВСГӨЛ АЙМГИЙН**
**РЭНЧИНЛХҮМБЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 20 өдөр                Дугаар А/03                Зөөлөн

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1,2 дахь заалт, Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.5, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит 10 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн төв хэсэг ахмадын байрны ар талд шинээр баригдах Соёлын төвийн байранд 0.09 га газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.
2. Газар эзэмшигч байгууллагын эрхлэгч \Д.Оюунчимэг\-тэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, Улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал \Б.Буянмөнх\-д үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга \О.Энхтүвшин\-д даалгасугай.

ДАРГА                Н.БАТСУУРЬ

МОНГОЛ УЛС

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН**
**ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН**

# ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар** 000007641

Соёлын төв / 4123417 /-д
*(байгууллагын нэр)* *(регистрийн дугаар)*

Сумын Засаг даргын -ын 20 20 оны 01 сарын 20 өдрийн А/03 тоот
*(шийдвэр гаргагч)*

шийдвэрийг үндэслэн Хөвсгөл Рэнчинлхүмбэ 6-р баг
*(аймаг, нийслэл)* *(сум, дүүрэг)* *(баг, хороо)*

Төв хэсэг Ахмадын байрны хойд талд ______ хаягт
*(гудамжны нэр)* *(хашааны дугаар/ тоот)*

байрлах, нэгж талбарын 6717001358 дугаар бүхий 900 м.кв /га/ газрыг

Соёлын цогцолбор барих зориулалтаар

15 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн ______

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.

**ГАЗРЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН**
**БАЙГУУЛЛАГА / АЛБАН ТУШААЛТАН**

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Газрын даамал 67170

**ТАМГА / ТЭМДЭГ** ______ / Б.Буянмөнх /
*(гарын үсэг)* *(нэр)*

**20** 20 **оны** 01 **сарын** 20 **өдөр**

## ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан, тамга |
| 1 | | | |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Газар эзэмших эрхийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

ГХГЗЗГ-ын даргын 2003 оны 157
тоот тушаалын 1-р хавсралт

Улсын бүртгэлийн дугаар_1_

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР
ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

2020оны 01 сарын 20 өдөр № 06728-2020/00001 Хөвсгөл аймаг, Ренчинлхүмбэ сум

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Газрын тухай хууль, ___*Хөвсгөл*___ аймаг /нийслэл/-ийн **Ренчинлхүмбэсум /дүүрэг/-ийн**Засаг даргын _*2020*_ оны *01* сарын _*20*_-ны өдрийн _**А/03**_ тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж , _*Хөвсгөл*_ аймгийн Ренчинлхүмбэсум /дүүрэг/-ийн газрын даамал *Баттулга* овогтой Буянмөнх, газар эзэмшигчийг төлөөлж **Соёлын төв-н овогтой** нар энэхүү гэрээг байгуулав.

**Хоёр. Гэрээний нөхцөл**

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ __900.0 м2__

Үүнээс:

| № | Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт | Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ | Төлбөрийн хэмжээ |
|---|---|---|---|
| 1. | Урлаг, соёлын байгууллага | 900.0 м2 | 7304 |

2.2. Газрын төлбөрийн хэмжээ:
Нэгжийн үнэ__8__төгрөг/үсгээр________________________/
Бүгд үнэ __7304__төгрөг/үсгээр__________________________/
Үүнээс:
1-р улирал__*1826*__төг 3-р улирал__*1826*__төг 2-р улирал__*1826*__төг 4-р улирал *1826*төг

2.3.Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар эзэмшүүлэгчийн **Хөвсгөл аймаг Төрийн Сан банкин дах 070000943** тоот дансанд шилжүүлж байна.
2.4. Газар эзэмшүүлэх тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гарсан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тогтооно.
2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчлэн тогтоолгоогүй бол зохих зардлыг газар эзэмшигч хүлээнэ.

**Гурав. Газар эзэмшигчийн эрх**

3.1. гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг эзэмших, ашиглах;

3.2. газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;

3.3. газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;

3.4. газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх, барьцаалах;

3.5. газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно.

3.6. газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр эрхийн гэрчилгээний хугацааг /*Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргах*/;

3.7. Газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болсон тохиолдолд эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон Засаг даргын шийдвэрийг эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

**Дөрөв. Газар эзэмшигчийн үүрэг**

4.1. газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;

4.2. газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;

4.3. газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх/ *5 жилд нэг удаа хийлгэнэ.*/;

4.4. бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
4.5. газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх;
4.6. төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх;

4.7. Эзэмшлийн газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх;

4.8. газар эзэмшүүлэгчээс газрын эзэмшил ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;

4.9. Кадастрын зураглал гүйцэтгэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өөрийн эдлэн газартаа саадгүй нэвтрүүлж, ажиллах, мэдээлэл авах боломжоор хангах

4.10. Өөрийн эдлэн газрын хилийн эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэглэсэн тэмдэгтийг хамгаалалтандаа авч, бүрэн бүтэн байдлыг хариуцах

4.11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлэх

4.12. Эдлэн газрын эргэлтийн цэгүүдийг хөдөлгөсөн, нүүлгэн шилжүүлсэн, устгахгүй байх

4.13. Геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шороонь ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга буюу хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.

4.14. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэх

4.15. Барилга байгууламжийн төлөвлөлтийн эскиз зургийг сум болон аймгийн ерөнхий архитектороор батлуулах

4.16. Барилга байгууламжийн зураг төсөл нь хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шийдлүүд, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай уялдсан байх бөгөөд барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас илүүгүй байна.

4.17. Барилгын улаан шугам тавихад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэнг оролцуулан баталгаажуулах

4.18. Гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг заасан хугацаанд арилгах арга хэмжээ авах

4.19 Эзэмшил, ашиглалтанд байгаа болон орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжид тохижилт, арилчилгаа хийх

4.20. холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

## Тав. Газар эзэмшүүлэгчийн үүрэг

5.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж байгаа эсэхийг хянах;

5.2. Уг газрыг эзэмшүүлэхийн зэрэгцээ дараах шаардлагыг газар эзэмшигчид тавих эрхтэй. Үүнд:

- Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх
- Эзэмшүүлэхээр олгосон газарт зориулалтын бус барилга байгууламж барих, хүн амын амьдрах орчны чанарт сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулахгүй байх
- Газрыг зориулалтын дагуу эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллах
- Хот тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана.
- Барилгын зургийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ба барилгыг мэргэжлийн байцаагчаар хянуулах
- Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд газар эзэмших гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах

5.3. Газрыг гэрээний нөхцөлийн дагуу эзэмшээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу Газрын тухай хуулийн 40.1.1-40.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тухайлбал:

- эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;
- газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;
- шилжүүлж авсан эрхийн гэрчилгээгээ улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;
- байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй;
- эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;
- хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр* гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй* зэрэг тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;
- Өмнөх гэрээний биелэлтээр илэрсэн зөрчлийг арилгуулах

5.4. газар эзэмшүүлэх гэрээг жил бүр дүгнэх;

5.5. холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

## Зургаа. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

6.1. газар эзэмшигчийн эзэмшилд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл **газар эзэмших эрх мөн адил шилжих болно** гэж шийдвэрлэнэ.

6.2. энэхүү гэрээгээр эзэмших газрыг хязгаартай эзэмших эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь **газрын тухай хуулийн 48-р зүйлд** заасан нөхцөлийг дагаж мөрдөх болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

6.3. Газар эзэмшигчийн газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гэрээний хугацаа дуусахаас өмнө эрх бүхий байгууллага улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргавал уг шийдвэрийн үндэслэл болсон талуудын урьдчилсан тохиролцоо болон бусад эрхийн актаар зохицуулна.
6.4. гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл: **Эзэмших эрх бүхий газраа зориулалтын дагуу эзэмшээгүй болон газрын төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулаагүй тохиолдолд газар эзэмших эрхийг нь хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ. Мөн зохих зөвшөөрөлгүйгээр газрын хэмжээнд өөрчлөлт оруулсан нөхцөлд газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.**

Жич: "**хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ...**" гэдгийг гэнэтийн давагдашгүй хүчний эсхүл байгалийн тогтолцооны өөрчлөлтөөс тухайн газарт нь эвдрэл, элэгдэл, цөлжилт бий болсон, бусдын хууль бус үйлдэл зэрэг газар эзэмшигчээс хамаарах шалтгаан байхгүй байсныг ойлгоно.

"**... зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй**" гэдгийг газар эзэмшүүлэх тухай гэрээ хийгдсэнээс хойш хуанлийн бүтэн 2 жилийн дотор газар эзэмшигч нь тухайн газар дээрээ гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй /барилга, байгууламж, зам талбай бариагүй, тариалан эрхлээгүй г. м/ байхыг ойлгоно.

**Долоо. Бусад зүйл**

7.1. Гэрээ нь газар эзэмшигчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.
7.2. Энэхүү гэрээг гурван хувь үйлдэж талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 15 жилийн хугацаатай байгуулав.
7.3. Газар эзэмшүүлэх гэрээг талууд жил бүр дүгнэх ба газар эзэмшигч гэрээний биелэлтийг жил бүрийн 06-р сарын 25-ны дотор багтаан тайлагнаж, газар эзэмшүүлэгч 07-р сарын 01-ний дотор багтаан дүгнэнэ.
7.4. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлээгүй, өмнөх гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, дахин давтагдсан тохиолдолд Газрын тухай хууль тогтоомжийн дагуу газар эзэмших, эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.
7.5. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
7.6. Газар олгох техникийн нөхцөл болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийн дагуу тухайн газар дээр байрлаж буй инженерийн шугам сүлжээг холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр нүүлгэн шилжүүлэх ба түүнтэй холбогдон гарах зардлыг газар эзэмших эрх авсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

**Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:**

Газар эзэмшүүлэгч Хөвсгөл аймгийн ГХБХГазар
Рэнчинлхүмбэ сумын 6-р баг, төв хэсэг "Нутгийн иргэдийн ордон" 102 дугаар өрөө
Утас: 99808007

Газар эзэмшигч: Донсолмаа *овогтой Оюунчимэг* Газар эзэмшигчийн хаяг: Хөвсгөл аймаг Рэнчинлхүмбэ сум 6-р баг Хуурч 8-15

Регистр / улсын бүртгэл /-ийн **4123417**
Банк, дансны дугаар: , None
Харилцах утас:80809422
И-мэйл хаяг : None

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар эзэмшүүлэгчийг төлөөлж:

Хөвсгөл аймаг / нийслэл/-ын *Ренчинлхүмбэ сум/-ийн газрын даамал* Баттулга овогтой Буянмөнх

_/гарын үсэг/ ________ /тамга/

Газар эзэмшигчийг төлөөлж:

*Соёлын төв-н эрхлэгч Донсолмаа овогтой* Оюунчимэг

/гарын үсэг/________ / тамга/

Энэхүү гэрээний нэг хувийг *6717001358* дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.

*Газар эзэмшүүлэгчийн төлөөлж гарын үсэг .......... Газар эзэмшигчийн гарын үсэг..................*

# Хөвсгөл аймгийн Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын Газар

Нэгж талбарын дугаар: 6717001358  Хуулийн этгээдийн нэр: Соёлын төв None

Ашиглалтын төрөл: эзэмших  Регистрийн дугаар: 4123417

**ХАЯГ:** Аймаг/Хот:Хөвсгөл  Сум/Дүүрэг: Ренчинлхүмбэ  Баг/Хороо: 6-р баг  Кадастрын муж: 170

тоот: Ахмадын байрны ард талд мж: Төв хэсэг




Орчны тойм:




Масштаб = 1:2500

Координатын систем:
WGS84 / UTM Zone 47N
EPSG: 32647

**Нэгж талбар**

| №. | X | Y | Урт |
|---|---|---|---|
| 1 | 546905.95 | 5661997.27 | 29.93 |
| 2 | 546935.87 | 5661996.67 | 30.02 |
| 3 | 546935.63 | 5661966.66 | 29.97 |
| 4 | 546905.67 | 5661967.18 | 30.11 |

**Барилга**

| №. | X | Y | Урт | Барилга/м2 |
|---|---|---|---|---|

Талбайн хэмжээ: 900 квадрат метр

Зураг хэвлэсэн ..........Б.Булмөнх
(Даамал )

Хянасан: ..............................Н.Батсуурь
(Сумын Засаг дарга)

Зургийн масштаб = 1:250 (1 сантиметрт 2 метр багтана)  Хэвлэсэн огноо: 2020-01-20

БАТЛАВ
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ХХК
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЗРЫН ДАРГА
.................................... Ж.ДАВААХҮҮ

# ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

ДУГААР: 2020/01/23

1. **ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА**: ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГХБХБГ
2. **ХЭРЭГЛЭГЧИЙН НЭР:** РЕНЧИНЛХҮМБЭ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ШИНЭ БАРИЛГА
3. **ХАРИЛЦАХ УТАС**:
4. **БАЙРШИЛ:** ХӨВСГӨЛ АЙМАГ РЕНЧИНЛХҮМБЭ СУМ 6-РБАГ
5. **ХЭРЭГЦЭЭ:** ХОЛБООЖУУЛАХ /ШИЛЭН КАБЕЛЬД ХОЛБОХ/
6. **Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа Холбооны Зохицуулах хорооноос олгогдсон үндсэн сүлжээ байгуулах бүрэн эрхийнхээ дагуу холбоожуулах техникийн нөхцлийг зөвхөн Мэдээлэл Холбооны Сүлжээ ТӨХХК /цаашид МХСТӨХХК гэх/ олгох бөгөөд техникийн нөхцөлгүйгээр холбооны бүх төрлийн үйлчилгээний зориулалттайгаар кабель татах болон шилжүүлсэн тохиолдолд уг барилга обьектыг техникийн болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

7. **Техникийн нөхцөлд тавигдах шаардлага:**
   a. Кабель татахдаа агаарын багана, худагт нөөц үлдээхгүй бөгөөд төгсгөлийн төхөөрөмж байрлуулах байрлалд нөөцийг авах шаардлагатай.
   b. Техникийн нөхцлийн дагуу угсралтын ажлыг гүйцэтгэж техникийн актыг хүлээлгэн өгөөгүй тохиолдолд тухайн чиглэлийн кабелийг шилжүүлэх, гадны гэмтэл саатал гарсан тохиолдолд гарах зардал болон хариуцлагыг МХС ТӨХХК хариуцахгүй болно.
   c. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагатай.

8. **Шаардагдах тоног төхөөрөмж, техникийн үндсэн нөхцөл**
   d. Ренчинлхүмбэ сумын МХСХХК-ийн салбарын байрнаас 400м агаарын шилэн кабелийг агаарын одоо ашиглаж байгаа 2, шинээр 2 багана босгон татаж шинэ барилгын шугам сүлжээний төгсгөлийн төхөөрөмжид /FDF/ холболт хийнэ. Зургийг хавсаргав.
      - Шилэн кабель – 400м
      - Баганы тоног -2ш
      - Бетон хөл -2ш
      - Багана-2ш
      - Медиа конвертор – 2ш
      - Төгсгөлийн төхөөрөмж /FDF/ - 2ш
      - Рак /4unit/ - 1 ш
      - Шилэн кабелийн корын залгаа – 8ш

- Муфьт /12 кор/-1ш

**9. Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцлүүд:**

a. Шинээр хийгдэх кабель, шугам болон худаг сувагчлалын төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 5280:2003, MNS 5277:2003 тоот ерөнхий шаардлагууд болон ДБХ-ийн сайдын 1995 оны 127-р тушаалаар батлагдсан зааврыг баримтлан гүйцэтгэх

b. Кабель татах трассын зураг гаргахдаа шаардлагатай худагт кабелийн болон муфьтны тавиур хийх ажлыг тусгаж өгөх.

**10. Угсралтын ажлын үед тавигдах нөхцлүүд:**

a. Шинээр татсан кабельд вирк бүрэн хийсэн байх ба кабель татах, FDF байрлуулах тохиолдолд тухайн байгууллагын техникийн өрөөний хананд тусгай тавиур хийж байрлуулсан байх.

b. Кабелийг агаараар татахдаа баганыг тоногоор тоноглож татна.

c. Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаарлагыг бүрэн хангуулсан байх.

d. Угсралтын ажил эхлэхийн өмнө тус газрын харъяалагдах шугам кабелийн тасагт мэдэгдэж кабель татах байршлыг заалган түүний дагуу гүйцэтгэх ба гүйцэтгэлийг МХСТӨХХК-ийн Хөвсгөл аймгийн газрын Кабель шугамын тасгийн ИТА-р хянуулан актанд тусгуулна. Хэрэв заагдсан нөхцлөөр татаагүй нөхцөлд ашиглалтын явцад шилжүүлэх шаардлага гарвал гарах зардлыг гүйцэтгэгч тал хариуцна.

**11.** Техникийн нөхцлийг Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын засаг даргын орлогч Ш.Далайбаяр-ын 2020-оны 01-р сарын 23 өдрийн № 02/23 тоот хүсэлтийг үндэслэн 2020-оны 01-р сарын 23 –ны өдөр олгов. Тус техникийн нөхцөл 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛИЙГ ХЯНАСАН: ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР..................Н.ШИРНЭНДОРЖ

БОЛОВСРУУЛСАН: КАБЕЛЬ ШУГАМЫН ИНЖЕНЕР..................Д.МЯДАГМАА




Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Соёлын төвийн шинэ барилгыг шилэн кабельд холбох зураглал

| | | | |
|---|---|---|---|
| Мэдээлэл Холбооны Сүлжээ Хөвсгөл аймгийн газар утас факс 70382350 | Гүйцэтгэсэн КШИ | Д.Мядагмаа | он/сар/өдөр |
| | Хянасан дарга | Ж.Даваахүү | |

Батлав.

Захирал ………………/Г. Очирхуяг/

**Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл : Дугаар № 05 / 2020**

2020 оны 01-р сарын 23- ны өдөр                                        Мөрөн сум

1. Техникийн нөхцөл хүссэн хэрэглэгчийн нэр: Хөвсгөл аймгийн ГХБХБГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзориг, Утас: 70382929
2. Хэрэглэгчийн байршил: Хөвсгөл аймаг, Ренчинлхүмбэ сум, 6-р баг
3. Ажил үйлчилгээний зориулалт: Ренчинлхүмбэ суманд шинээр Соёлын төвийн барилга барих
4. **Техникийн нөхцөл олгох үндэслэл:** Хөвсгөл аймгийн ГХБХБГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзоригын 2020 оны 01-р сарын 23-ны өдрийн №4/34 албан тоотын дагуу
5. Суурилагдсан чадал - 60 кВт.
6. Холбогдох цэг: Ренчинлхүмбэ сумын ЕБС-ийн шинээр барихаар төлөвлөгдсөн дэд өртөөнөөс ачаалалд тооцсон хос кабелиар хэрэглээг тэжээх.
7. Тоолуур : / DTZY88/ марктай дүйцэхүйц 3 фазын электрон тоолуур
8. Гүйдлийн трансформатор: байхгүй
9. **Тусгай заалтууд**: (Энэ дэд өртөө шугамыг өргөтгөх,шугамын трасс өөрчлөх, гадны хэрэглэгчийн шугамаас тэжээхэд тавигдах шаардлага болон шаардлагатай бусад заалтууд орно).
10. **Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа:** 1 жил

**Щит тоноглолын болон газардуулгыг норм дүрэм стандартын дагуу хийх.** / Зайлшгүй газардуулга хийж хангагч байгууллагын эрх бүхий ажилтнаар хэмжүүлж акт гаргуулж авах шаардлагатай/

Дор дурьдсан техникийн даалгавар, хууль, дүрмийг мөрдөх:

Дээр өгөгдсөн холболт хийх цэгээс холбогдох дүрэм зааврын дагуу шугам татан авч, тоног төхөөрөмжийн газардуулгыг норм стандартын дагуу хийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлэн акт гаргуулан авах

Кабель шугамын трасс, хамгаалалтын зурваст барилга барих, зам талбай засах, бетондохыг хориглоно.

Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар цахилгаан техникийн байгууламжийн дүрэм , аюулгүй ажиллагааны дүрэм , техник ашиглалтын дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.

Хүчдэлийн түвшингийн ± 5%-ийн хэлбэлзэлд зохицсон тоноглол суурилуулах.

Засгийн газрын 2001 оны өдрийн 263 тоот тогтоолоор батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн заалтыг мөрдлөгө болгох.

Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр , орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч,

эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно. (Хэвийн бус үйл ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээ хийлгэх)

Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.

Цахилгаан эрчим хүчний тооцоог сар бүрийн 20 -ны дотор хийх.Хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуулийн 30.1.11-д заасны дагуу хүчин чадлын хүрээнд тус компанийн зөвшөөрлөөр шинээр хэрэглээг нэмэх бол зөвшөөрөл авч холбуулах үүрэгтэй.

Техникийн комиссын дарга……………………Д.Отгонбаяр

Гишүүд……………………………Г.Даваадорж

……………………………Д.Нарантунгалаг

89002992.

“ Хөвсгөл Эрчим Хүч ” ХХК

Шинэ хэрэглэгчийг цахилгаан сүлжээнд холбосон тухай протокол.

11. Холболтын дугаар
12. Хэрэглэгчийн нэр
13. Хэрэглэгчийн байршил
14. Олгогдсон техникийн нөхцөлийн

Огноо

Дугаар

15. Цахилгаан эрчим хүчээр хангах , хэрэглэгчийн гэрээний

Огноо

Дугаар

16. Хэрэглэгчийг холбосон дэд станцын дугаар
17. Хэрэглэгчийн холбосон ячеекийн дугаар
18. Хэрэглэгчийг холбосон кабелийн өгөгдлүүд

Марк
Туршилтын хүчдэл
Урт
Кабелийн үзүүр дэх таних тэмдэг

19. Суурилуулсан тоолуурын өгөгдлүүд

Марк, заводын дугаар
Гүйдлийн трансформаторын марк
Коэффициент
Баталгаажуулсан огноо
Суурилуулсан байршил
Холболт хийх үеийн заалт

20. Тоолуурын тип марк ............................... заалт .................

Лацын дугаар............................3-р лац хийсэн..............он...........сар...............өдөр.............

Лац хийсэн: Байцаагч монтёр.......................... / Г.Нямдорж /

Холболт хийх тоноглолуудыг хянан баталгаажуулсан:

Ашиглалтын хэсгийн мастер / Х.Цанжидмонлом /

Газардуулгыг хэмжиж акт үйлдсэн:

ДРХ-ын хэсгийн инженер /Б.Хишигбаатар/

............................................

Монтёр ..................................................

Хэрэглэгчийн төлөөлөгч ..........................

Холболт хийсэн огноо, цаг ...............................

БАТЛАВ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РЭНЧИНЛХҮМБЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА Н.БАТСУУРЬ

# РЭНЧИНЛХҮМБЭ СУМАНД БАРИГДАХ СОЁЛЫН ТӨВИЙН ШИНЭ БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2019.01.15

Зөөлөн.

| | | |
|---|---|---|
| 1 | Зураг, төсөв зохиох үндэслэл. | Аймгийн сумын засаг даргын үр дүнгийн гэрээний биелэлт, Хөгжсөн хөвсгөл – 2030 хөтөлбөр Өв соёл – Эрч хүч хөтөлбөр. |
| 2 | Барилга байгууламжийн нэр байршил. | Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын төвд шинээр баригдах Соёлын төвийн барилга. |
| 3 | Архитектур төлөвлөлтийн шаардлага хүчин чадал. | Орчин үеийн өнгө үзэмжинд нийцсэн шинэлэг шийдэлтэй стандартын дагуу байх. |

| | |
|---|---|
| Нэг. Сумын Соёлын төвийн барилгын шаардлага. | 1.Үзэгчдийн тахим ( 250 – 300 хүний суудалтай)<br>2.Биеийн тамир, бүжгийн тахим – 2<br>3.Номын сангийн фондын өрөө (дунджаар 20,0 – 30,0 мянган номын багтаамжтай)<br>4.Уншилагын танхим (20-50 хүний суудалтай)<br>5.Урлаг, уран сайхны бүлгэм дугуйлан, хамтлаг хичээллүүлэх өрөө, жүжиг, найрал дуу, хөгжим бүжиг (2 – 4)<br>6.Орон нутаг сурталчилах танхим – 1<br>7.Тоглолтын бэлтгэлийн өрөө – 2<br>8.Ажлын өрөө таслагаа – (захирал, хөгжмийн багш, номын санчын өрөө)<br>9.Эд хогшлын агуулах – 1<br>10.Буфет үйлчилгээний өрөө – 1<br>11.Сонирхогчдын нэгдэл клубын өрөө – 1<br>12.Зан үйл танхим – 1<br>13.Кино зураг, үзель техникийн өрөө – 1<br>14.Тоглоомын танхим<br>15.Хүлээх танхим буюу мэдээлэлийн танхим – 1<br>16.Хувцасны танхим – 1<br>17.Бие засах газар – 2<br>18.Соёлын төвийн орчимд амралтын цэцэрлэгт хүрээлэн гэрэлтүүлэг машины зогсоол, дулааны улиралд зохиогдох соёл, чөлөөт цагийн ажлын зориулалттай задгай талбайтай байх. |
| Хоёр. Сумын соёлын төвд байвал зохих зориулалтын техник хэрэгсэл, бусад эд хогшил тавилга. | 1.(Led фон) - 6м*6м<br>2.Өсгөгч (чадлын өсгөгч) нүүдлийн суурин – 2ш<br>3.Чанга яригч – 2ш (суурин)<br>4.Соёлын төвийн зориулалттай проектор – суурин<br>5.Дэлгэц<br>6.Өнгөт принтер, (комфьютер, суурин)<br>7.Комфьютерийн ширээ сандал – 3<br>8.Хурлын ширээ сандал – (6 хос)<br>9.Индэр – 1ш<br>10.Микрофони – 6ш<br>11.Ажлын ширээ сандал – 3<br>12.Цефийн зориулалттай шкаф – 3ш<br>13.Хивс – 3ш |

| | |
|---|---|
| | 14.Бүжгийн танхимын дрож<br>15.Ханын толь – 12ш |
| Гурав. Гэрэлтүүлэгийн тоног төхөөрөмж. | 1.Тайзны хажуугийн гэрэл – 4*2=8ш<br>2.Тайзны нүүрний гэрэл – 4ш<br>3.Тайз гэрэлтүүлэгч – 30ш |
| Дөрөв. Барилга байгууламжийн бүрэлдхүүн. | Барилгын 30м*30м Орчин үеийн барилгын стандарт норм дүрэмд нийцсэн эрүүл ахуйн шаардлага хангасан эко материал сонгож төлөвлөх.<br>Тааз:Модон рам зангидаж канапаар өнгөлөх.<br>Шал:Дулаалгатай бетонон шал цутгах, даацын хулдаас хийх буюу паркетлах.<br>Цахилгаан:Цахилгааны монтажийг хийх. Цахилгаан байгууламжийн дүрэм БД 43 – 101 – 03, цахилгаан техникийн ажил БНбД – 3,05,06, -90,цахилгаан техникийн аюулгүй ажиллагааны дүрэм.<br>Бусад:Аюулгүй байдлыг хангах зорилгоор утаа мэдрэгч, хяналтын камер төлөвлөж өгөх.<br>- Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм дүрэм (БНбД 30 – 01 – 04)<br>- Олон нийтийн барилгын норм дүрэм (БНбД 31,03,03)<br>- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм (БНбД 301 – 06 – 90)<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч, зам, налуу шатыг шийдэх (MNS 6056:2003, 6055 – 2009)<br>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм.<br>- Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг (БНбД 23 – 02 – 08) Бусад норм дүрэм стандартын дагуу төлөвлөх. |
| Тав:Барилга үндсэн бүтэц, материал. | Суурь:Төмөрийн бетон шугаман<br>Хана:Дулаалгатай тоосго хана дулаан техникийн тооцоогоор тухайн сумын хүйтний эрчим, байгаль цаг уурын онцлогийг үндэслэн орчин үеийн дэвшилтэт техникийн БНбД 31-02-03 үндэслэн орчин үеийн дэвшилтэт технологиор төлөвлөх.<br>Барилгын дулаан техникийн БНбД 31-02-03<br>Хучилт:Цутгамал төмөр бетон хучилт Цутгамал төмөр бетоны ажлыг БНбД 83-4Б-01<br>Дээвэр:Шувуу нуруун дээврийн ажлыг БНбД 31-07-05, БД 31-108-08 норм дүрмүүдээс холбогдох заалтуудыг авч төлөвлөнө.<br>Дулаан техникийн тооцоогоор тухайн сумын хүйтний эрчим, технологиор төлөвлөх. Барилгын дулаан техникийн БНбД 31-02-03 дээврийн ажил БНбД 31-07-05<br>Засал: орчин үеийн барилгын стандарт норм дүрэмд нийцсэн ард иргэдийн ахуйн шаардлагад нийцсэн эко материал сонгож төлөвлөх.<br>Цонх: 3 давхар шилтэй хуванцар рамтай<br>Хаалга: Дулаалгатай металл хаалга үйлдэврийн стандартын шаардлага хангасан сайн чанартай, зориулалтын, шинэ дэвшилтэт материал ашиглахаар төлөвлөх. |
| Зургаа.Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр. | Цахилгаан ханамж: Эрчим хүчний эх үүсвэрээс татах.<br>Дулаан ханшамж: Нэгдсэн халаалт<br>Холбоо, дохиолол: Техникийн нөхцлөөр, галын дохиолотой байна.<br>Агаар сэлгэлт: Тооцооны үндсэн дээр оновчтой төлөвлөсөн агааржуулалтын системтэй байх. |

| | |
|---|---|
| Долоо:Зураг төслийн иж бүрдэл. | Зургийн төслийн иж бүрдэл:<br>**4.Эскиз /батлагдсан/**<br>**5.Ажлын зураг /батлагдсан/**<br>**6.Ажлын төсөв /батлагдсан/**<br>**Зураг төсөлд тавигдах шаардлага:**<br>**Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх.** |
| Найм: Зураг төсөв зохиох үе шат. | ✓ 1 үе шаттай<br>✓ Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно. |
| Ес: Зураг төслийн байгууллага. | "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" Монгол улсын хуулийн дагуу зөвлөх үйлчилгээгээр сонгон шалгаруулна. Зураг төслийн тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж зураг төсөл боловсруулах дүрмийн дагуу /БНбД 11-01-98/ хийж гүйцэтгэнэ. |
| Арав: Хөрөнгө оруулагч байгууллага. | Улсын төсөв 1,4 тэрбум |
| Арван нэг: Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх хугацаа. | 2020 – 2021 |
| Арван хоёр: Онцгой нөхцөл. | ✓ Үер ус, аянга цахилгаанаас урьдчилан сэргийлэх байдлыг хангасан байна.<br>✓ Газар хөдлөлтийн бүс барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм БНбД 22-01-01-ийн 2,5-ын 4-р хүснэгтийн 5-д заасан үндэслэлээр газар хөдлөлтийг тооцох.<br>✓ Барилгын аврах гарцыг норм дүрмийн дагуу төлөвлөх ба саадгүй, түргэн аврагдах гарцыг төлөвлөх.<br>✓ Галд шатдаг материал барилгын үндсэн хийцэд ашиглахгүй байх.<br>✓ Барилгын дотор заслыг хүүхдийн орчин бүрдүүлсэн, өнгө үзэмжтэй байх.<br>✓ Зураг хийхдээ газар дээр нь хэмжилт хийх.<br>✓ Харагдах байдал, гадна орчны өнгө үзэмжийг одоо байгаа барилгуудтай уялдуулна. |
| 13.Галын аюулгүй байдлын нөхцөл. | "Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНбД 21-01-02, "Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм" БНбД 21-02-02", норм дүрмүүдээс холбогдох заалтуудыг авч төлөвлөнө. |
| 14.Байгаль орчны үнэлгээ. | Шаардлага. |

ЗУРГИЙН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН:

РЭНЧИНЛХҮМБЭ СУМ СОЁЛЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ Д.ОЮУНЧИМЭГ

ХӨГЖМИЙН БАГШ,ӨВИЙН АЖИЛТАН Д.ЧИНБАТ

НОМЫН САНЧ, НЯРАВ Д.НИМБАТ